



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

20 оны 10 сарын 20 едер

Дугаар 524

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооолор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4,500,000.00 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийн балансын үнэ, 937,500.00 /есөн зуун гучин долоон мянга таван зуун/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дашдэмбэрэл, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээд /Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар/-д эзэмшүүлэх, ашиглуулах, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Дээрх автомашиныг хүлээлцсэн акт, эзэмшигчийг шилжүүлсэн тодорхойлолтыг арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
524 дугаар тогтоолын хавсралт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний өрөнхий газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй төрийн өмчийн
данс бүртгэлээс хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Ниссан Кашкей, 06-66 УБҮ, арал № SJNFBNJI0Z2254846	2011/ 2020	4,500,000.00	937,500.00
	Нийт дүн		4,500,000.00 /дөрвөн сая таван зуун мянган/	937,500.00 /есөн зуун гучин долоон мянга таван зуун/